



I-II/2022

Тархаасан: 2022 оны 3 дугаар сарын 14



## Улсын хэмжээнд 32.3 мянган мал хорогдсон байна

Том малын зүй бус хорогдол 2022 оны эхний 2 сард улсын хэмжээнд 32.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 508.1 мянгаар буурсан байна.


Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, ямаа 14.0 мянга, хонь 12.2 мянга, үхэр 3.8 мянга, адуу 2.2 мянга, тэмээ 36 толгойгоор тус тус хорогдсон байна. Нийт хорогдсон малын 43.4 хувийг ямаа, 37.7 хувийг хонь эзэлж байна.

### ХҮСНЭГТ 1. ХОРОГДСОН ТОМ МАЛ, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, төрлөөр

Малын төрөл	Хорогдсон том мал				Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь			
	2019 I-II	2020 I-II	2021 I-II	2022 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II	2022 I-II
	мянган толгой				хувь			
<b>Дүн</b>	<b>165.9</b>	<b>174.0</b>	<b>540.4</b>	<b>32.3</b>	<b>0.25</b>	<b>0.25</b>	<b>0.81</b>	<b>0.05</b>
Адуу	7.3	8.8	26.0	2.2	0.18	0.21	0.55	0.05
Үхэр	15.0	13.9	52.9	3.8	0.34	0.29	1.29	0.08
Тэмээ	0.1	0.1	3.3	0.0	0.03	0.02	0.69	0.01
Хонь	59.2	80.1	159.6	12.2	0.19	0.25	0.53	0.04
Ямаа	84.3	71.1	298.6	14.0	0.31	0.24	1.08	0.05

Хорогдлыг аймгаар нь авч үзэхэд 2022 оны эхний 2 сарын байдлаар Архангай аймагт 4.4 (13.6%) мянга, Хэнтий аймагт 4.2 (13.0%) мянга, Ховд аймагт 4.1 (12.7%) мянга, Хөвсгөл аймагт 3.4 (10.5 %) мянга, Баян-Өлгий аймагт 3.2 (9.8%) мянган мал хорогдсон нь нийт хорогдлын 59.6 хувийг эзэлж байна.


### ЗУРАГ 1. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, аймаг, нийслэлээр, 2022 оны эхний 2 сарын байдлаар, мянган толгой



Улсын хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон 30.8 сая эх малын 7.4 мянга (0.02%) нь 2022 оны эхний 2 сард хорогдсон байна. Архангай, Хөвсгөл, Ховд, Хэнтий аймагт хээлтэгч мал 0.8-2.1 мянгаар хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 60.9 хувийг эзэлж байна. Харин 649 хээлтүүлэгч хорогдсоноос бух 241, ухна 197, хуц 158, азарга 53 тус тус байна.

Улсын хэмжээнд 2022 оны эхний 2 сард 1.6 мянган мал өвчнөөр хорогдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 486 (45.1%) толгойгоор өссөн байна.

ЗУРАГ 3. ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар



Хорогдсон нийт том малын 93.4 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асгаас унах, өлдөх, осгох зэрэг шалтгаанаар хорогдсон бол 1.8 хувь нь аюулт үзэгдлээр, 4.8 хувь нь өвчнөөр хорогдсон байна.

### Ойлголт, тодорхойлолт

**Том малын зүй бус хорогдол:** Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.



### Оны эхний мэдээ том малын зүй бус хорогдлын эзлэх хувь:

Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

### Эх үүсвэр:

ҮСХ, Том малын зүй бус хорогдлын мэдээ

### Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

### Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 4 дүгээр сарын 13

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Э.Болормаа  
Утас: (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212